

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 10-ны өдөр

Дугаар

БА-059/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 9 давхар, 40.8м*15.5м хүчин чадал бүхий конторын зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/10/05 огноо, 0013826 дугаар, БАЗГ2023/761;

2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЭТ-01/2021;

2.3 Захиалагч: Татварын ерөнхий газар УТҮГ оноосон нэр, 9070006149 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6097898 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, С.Данзангийн гудамж 4А, Татварын ерөнхий газрын байр, 11-321309 холбоо барих утас, 99076466 цахим хаяг;

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ оноосон нэр, 9013001019 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5164753 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот 210644, Чингэлтэй дүүрэг, Их тойруу-1 Баруун 4 зам, Барилгын хөгжлийн төв. Холбоо барих утас 70110298, цахим хаяг: info@barilga.gov.mn

2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: Бумбод ХХК оноосон нэр, 9011029021 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2810786 регистрийн дугаар, БУ17-213/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, Бумбод плаза 3-р давхар, 91922303 холбоо барих утас;

2.5 Барилга байгууламжийн Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй;

2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Эрчим төсөл ХХК оноосон нэр, 9011423096 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, ЗТ19-117/21 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10 дугаар хороо, 7-р хороолол, Их тойруу-60, 503, 504, 506, 508 тоот, 99118897 холбоо барих утас;

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

ГАЗАР

оруулах комисс

2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс оноосон нэр, 9070002129 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 90870014 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, Элистейн гудамж, 80004786 холбоо барих утас;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан;

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул
- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 9 давхар, 40.8м*15.5м хүчин чадал бүхий конторын зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

Барилга байгууламжийг а
оруулах комисс

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт хуудас, хуралдааны тэмдэглэл хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 9 давхар, 40.8м*15.5м хүчин чадал бүхий конторын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо, Татварын ерөнхий газрын захиалгатай зорьтой 9 давхар, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн конторын барилга

Комиссын дарга:

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)


Комиссын нарийн бичгийн дарга:

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын
Барилга байгууламжийн захиалагч,
хяналтын хэлтсийн хяналтын инженер




(Г.Золбоо)

Татварын ерөнхий газрын
Санхүү, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга



(Л.Бямбадорж)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.




СҮХБААТАР ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬТОЙ 9 ДАВХАР, СҮХБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ТАТВАРЫН ХЭЛТСҮҮДИЙН КОНТОРЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд Татварын ерөнхий газрын захиалгатай зорьтой 9 давхар, 40,8м*15.5м, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсүүдийн конторын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 2 дугаар давхарын хурлын танхимд 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 13:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15:00 цагт дуусав.



Хуралд:

- | | | |
|----|---|-------------------------|
| 1 | Комиссын дарга: Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | Б.Батчимэг |
| 2 | Нарийн бичгийн дарга: Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын Барилга байгууламжийн захиалагч, хяналтын хэлтсийн хяналтын инженер
Татварын ерөнхий газрын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга | Г.Золбоо
Л.Бямбадорж |
| 3 | Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Г.Батбаатар |
| 4 | Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 5 | Барилга хөгжлийн төвийн Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер | О.Ундрах |
| 6 | Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга | Д.Сүхбат |
| 7 | Улаанбаатар цахилгаан түгээх ТӨХК-ийн техник хяналтын инженер | Ц.Билигт |
| 8 | Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн | Н.Болор-Эрдэнэ |
| 9 | Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төвийн инженер | Б.Жамбалцанчид |
| 10 | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, дэд хурандаа | Ч.Артаг |
| 11 | Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч | Я.Чулуун |
| 12 | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Төв түгээх төвийн инженер | Д.Мандахтуяа |

- | | | |
|----|---|---------------|
| 13 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан | Н.Эрдэнэтөгс |
| 14 | Зураг төслийн Эрчим төсөл ХХК-ийн захирал | Ц.Сэргэлэн |
| 15 | Гүйцэтгэгч Бумбод ХХК-ийн захирал | Ц.Отгонбаатар |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд Татварын ерөнхий газрын захиалгатай зорьтой 9 давхар, 40,8м*15.5м, Сүхбаатар, Чингэлтэй дүүрийн татварын хэлтсүүдийн конторын зориулалттай барилгыг барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Татварын ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга **Л.Бямбадорж:**

- Давхар бүрийн орц гарцын тэмдэг хийх.
- Техникийн өрөө давхруудын цахилгааны шкафуудын хаягжуулах.
- Барилга угсралтын дараах цэвэрлэгээнд анхаарах.
- Комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлэх.

Үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч Бумбод ХХК-ийн захирал **Ц.Отгонбаатар:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч Эрчим төсөл ХХК-ийн захирал **Ц.Сэргэлэн:**

- Цахилгааны самбаруудад хаягжуулалт хийх.
- Техникийн давхарт гүйцэтгэлийн зураг хийх

Үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төвийн инженер **Б.Жамбалцанчид:**

- Цэвэр усны огтолгооны хаалтыг задушка хаалтаар солих.
- Гадна цэвэр бохир усны шугамын ажлын зургийн өөрчлөлтийг шалгуулах.
- Усны тоолуурыг баталгаажуулах.
- Усны нөөцийн савыг халдваргүйжүүлэлт хийсэн акт усны шинжилгээний дүгнэлт шалгуулах.

- Бохир усны худгийг янзлах. Дулаалга хийх.
Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан **Н.Эрдэнэтөгс:**

- Гаднах явган замд харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам хийх.
- Автомашины зогсоолоос явган хүний зам руу гарах хэсэгт бордюрыг стандартын дагуу налуу хий.
- Автомашины зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолыг стандартын дагуу босоо болон хэвтээ тэмдэг тэмдэглэгээ хийх 2 ширхэг.
- 1 дүгээр давхрын хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан эр эм ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан стандартын тоноглолоор тоноглох угаагуур, суултуур, шээлтүүр.
- 2-оос 6 дугаар давхар хүртэл нийтийн ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулснаар угаалтуур суултуурыг тоноглох.
- Захиалагч болон зураг зохиогчтой зөвшилцсөн энэ ажлыг заавал хийж гүйцэтгэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төв ТӨҮГ-ын Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **О.Ундрах:**

- Дээврийн дотуур усны хаялганы хог шүүгч тавих.
- 3 метрээс дээш өндөртэй дотор өрлөгт ханын хучилтад хийгдсэн бэхэлгээний далд ажлын акт. Фото зураг нөхөж үзүүлэх.
- Дээврийн прогоны С ган татлага нэг үе явсан байна. Зохиогч байгууллага тайлбар албан тоот ирүүлэх.
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу гэрээ байгуулсан. Төсвийн хүрээнд нормчлын сангийн шимтгэл төлөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний Төв архивын Зураг төслийн баримтын архивын эрхлэгч **Я.Чулуун:**

- Хувийн хэрэгт магадлалын ерөнхий дүгнэлт, хавсралт хийх.
 - Лифтний дүгнэлт, акт зэргийг хавсаргаж, баримт бичгийн бүрэн бүрдэлтэй болгох.
 - Барилга угсралтын ажлын улаан дэвтрийг бүрэн баталгаажуулах.
 - Ажлын зураг болон үндсэн баримтын эх хувийг архивд хүлээлгэж өгөх.
 - Үндсэн баримт бичгийг архивын заавар журмын дагуу цэгцлэх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, дэд хурандаа **Ч.Артаг:**

- Усны нөөцийн савны тооцоо болон даралтыг хэмжиж үзүүлэх.
- Техникийн давхарт байгаа утаа мэдрэгчийн байрлалыг өөрчлөх.
- Техникийн давхарт гүйцэтгэлийн зураг зохиогч гаргаж баталгаажуулах.
- Барилга угсралтын ажлын гэрээг сунгах.

- Ажил дууссан өдрөөс барилгын тухай хуулийн дагуу чанарын баталгааг гаргах.
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Төв түгээх төвийн инженер **Д.Мандахтуяа:**

- Дулааны худгийн 5 хос шугамыг өнгийн туузаар ялгаж ороох.
- ХҮТ 6-тай гэрээ хийх.
- Дулааны үзэлт дулааны тоолуурын буцах даач мэдэхгүй ажиллагаанд оруулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын инженер

Ц.Билигт:

- Шинэ хэрэглэгчийг сүлжээнд залгах зөвшөөрлийн бичиг.
- Узелийн тоног төхөөрөмжийг газардуулгын хүрээнд холбох.
- Лоткийг гүйцээж хийх.
- Цахилгааны самбарт вирк схем хаяг плакат хийх.
- Давхрын самбарт хаяг верк хаалт хийх.
- Техникийн давхарт хүрээ газардуулга гүйцээж хийх. Лифт сэнсний өрөө

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн

дарга **Д.Сүхбат:**

- Халаах хэрэгсэлд балансын хаалт тавих.
- Дулааны худагт цэвэрлэгээ болон шат хийх.
- Агаар халаагчийн үзэлд дулаалга хийх.
- Автомат хаалтын активотор суурилуулах.
- Давхар болгоноор хаягжуулалт хийх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн

мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ:**

- Зааланд зарлан мэдээлэх суурилуулах.
- Зоорины давхрын өөрчлөлтийн зураг шалгуулах.
- Давхар дундын самбар өөрчилсөн талаар авторын дүгнэлт.
- Давхрын самбар хаягжуулах.
- Гадна холбооны гүйцэтгэлийн акт шалгуулах.
- Дотор холбооны ил далд ажлын актуудыг нөхөж үзүүлэх.
- Дотор холбоо дохиолол угсарсан компанийн тусгай зөвшөөрөл шалгуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний

хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна дулааны худаг цэвэрлэж шугам будаж дулаалан ус буулгагч угсрах.
- Агааржуулалтын системийн механик системүүдийг байнгын ажиллагаанд оруулж ашиглалтын зааварчилгааг ашиглагчид байгууллагад өгөх.

- Нөөцийн сав ариутгал хийлгэж ундны усны шинжилгээнд өгч нийслэлийн эрүүл мэндийн газрын байцаагчийн дүгнэлт гаргуулах.
- Узелд ус зайлуулах трап хийх.
- Гал зуухны өрөөний зонт угсрах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга. Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Г.Батбаатар:**

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр үзүүлэх.
- Лифтийг магадлалд оруулсан дүгнэлт үзүүлэх.
- Техникийн давхрын гүйцэтгэлийн зургийг баталгаажуулж үзүүлэх.
- Дээврийн ус зайлуулах хоолойд шүүр хийх.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тоноглол хийх.
- Гадна тохижилтыг зураг төслийн дагуу хийж дуусгах.
- Гадна авто зогсоолын асуудлыг яаж шийдсэн талаар гэрээ албан тоотыг ирүүлэх.
- Улаан дэвтрийг бүрэн баталгаажуулах.
- Барилгад хэрэглэсэн материалын тохирлын гэрчилгээ сертификат үзүүлэх. цонх хаалга.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг:**

- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 чанарын баталгаа албан бичгийг ирүүлэх.
- Өргөх ба цахилгаан шатны магадлалын дүгнэлт танилцуулах.
- Спорт заалны үзэгчийн модон суудал хийх.
- Өрөө тусгаарлах шилэн хананы шинжилгээний бичиг ирүүлэх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сүхбаатар Дүүргийн 11 дүгээр хороо, Татварын ерөнхий газрын захиалгатай зоорьтой 9 давхар, 40,8м*15.5м, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн Татварын хэлтсийн конторын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын ганд гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Б.Батчимэг

Тэмдэглэл хөтөлсөн:

Комиссын нарийн бичгийн дарга:
Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын
Барилга байгууламжийн захиалагч,
хяналтын хэлтсийн хяналтын инженер



Г.Золбоо

Татварын ерөнхий газрын
Санхүү хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга



Л.Бямбадорж